

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чингис хот

2022 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа
Утас: 99028942 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

Contents.....	1
1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Албан шаардлага	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
6. Аудитын тайлангийн хавсралт.....	17
6.1. Албан шаардлага 2021.03.07 №	ХЭА-2022/64/НА-СТА-ТШЗ
Bookmark not defined.	Error!

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 150
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ГЭРЭЛМАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

025081240

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,696,257.98	79,149,270.00
33	АВЛАГА	5,456,887.98	5,400,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	56,887.98	-
335	Бусад авлага	5,400,000.00	5,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	5,400,000.00	5,400,000.00
34	УРЬДЧИЛГАА	8,833,000.00	17,024,300.00
34600	Урьдчилж гарсан зардал	8,833,000.00	17,024,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,406,370.00	56,724,970.00
354	Хангамжийн материал	65,681,370.00	47,124,970.00
35410	Бичиг хэргийн материал	984,400.00	861,000.00
35420	Аж ахуйн материал	61,859,970.00	42,651,970.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,387,000.00	3,612,000.00
35440	Түлш, шатах тослох материал	450,000.00	-
35600	Мал амьтад	8,725,000.00	9,600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,657,216,202.34	1,499,043,962.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,657,216,202.34	1,499,043,962.01
392	Биет хөрөнгө	1,633,706,002.34	1,474,492,212.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,567,193,232.97	1,331,385,525.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(161,052,303.61)	(165,146,374.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,905,705.00	163,051,205.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,385,235.10)	(58,939,345.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,648,792.40	93,969,999.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,845,601.87)	(46,712,988.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,259,397.39	61,612,150.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,979,948.12)	(28,546,457.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	211,769,882.00	245,069,082.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(105,807,918.72)	(121,250,584.80)
393	Биет бус хөрөнгө	23,510,200.00	24,551,750.00
39301	Програм хангамж	1,542,000.00	2,410,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,245,800.00)	(716,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	23,214,000.00	22,858,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,745,912,460.32	1,578,193,232.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,745,912,460.32	1,578,193,232.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,745,912,460.32	1,578,193,232.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	399,748,482.67	399,748,482.67
51101	Өмч: - төрийн	399,748,482.67	399,748,482.67
512	Хуримтлагдсан үр дүн	1,291,810,704.50	1,124,091,476.19
51210	Өмнөх үеийн үр дүн	1,291,810,704.50	1,291,810,704.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	(167,719,228.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,353,273.15	54,353,273.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,745,912,460.32	1,578,193,232.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	625,344,568.00	647,545,576.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,024,000.00	76,870,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	166,024,000.00	76,870,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	166,024,000.00	76,870,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	934,000.00	982,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	165,090,000.00	75,887,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	459,320,568.00	570,675,276.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,806,668.00	47,874,476.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,941,339.00	26,995,706.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,865,329.00	20,878,770.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,513,900.00	522,800,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,513,900.00	522,800,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	623,148,308.55	612,749,484.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	623,148,308.55	599,249,484.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	576,354,723.60	559,298,212.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,644,835.52	212,763,128.44
210101	Үндсэн цалин	161,229,978.52	156,803,170.67
210102	Нэмэгдэл	44,222,857.00	52,605,957.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,192,000.00	3,354,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,417,950.84	27,746,145.49
210201	Тэтгэврийн даатгал	18,222,617.12	19,415,574.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,151,659.10	2,152,831.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,677,650.81	1,715,545.16
210204	Ажилгүйдлийн даатгал	396,911.25	405,654.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,969,112.56	4,056,540.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,499,667.71	61,545,422.61
210301	Гэрэл, цахилгаан	5,715,536.71	5,467,422.61
210302	Түлш, халаалт	59,784,131.00	54,978,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,104,056.00	23,739,918.00
210401	Бичиг хэрэг	2,641,200.00	2,331,650.00
210402	Тээвэр, шатахуун	14,583,312.00	15,929,194.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,224,744.00	2,128,624.00
210404	Ном, хэвлэл	18,500.00	6,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	636,300.00	3,343,950.00
2105	Нормативт зардал	349,000.00	165,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	349,000.00	165,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,066,100.00	28,588,650.00
210602	Тавилга	-	15,697,000.00
210604	Урсгал засвар	30,066,100.00	12,891,650.00
2107	Томилолт, зочны зардал	6,071,500.00	5,282,000.00
210702	Дотоод албан томилолт	6,071,500.00	5,282,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,082,183.00	31,419,566.65

**Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,176,476.00	25,916,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,840.00	502,450.00
210804	Тээврийн хэрэгслийн тагвар	281,100.00	205,666.65
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	31,767.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,119,430.53	168,048,181.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,348,362.00	57,416,561.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	965,700.00	320,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,805,368.53	110,311,620.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,793,584.95	39,951,271.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,220,000.00	6,595,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,220,000.00	6,595,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,573,584.95	33,356,271.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,573,584.95	33,356,271.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,500,000.00
223001	Бусад хөрөнгө	-	13,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,196,259.45</u>	<u>34,796,091.89</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,255,182.21	202,515,320.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,255,182.21	202,515,320.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,255,182.21)	(202,515,320.20)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>941,077.24</u>	<u>(167,719,228.31)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	399,748,482.67	54,353,273.15	1,291,810,704.50	1,745,912,460.32
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	399,748,482.67	54,353,273.15	1,291,810,704.50	1,745,912,460.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	399,748,482.67	54,353,273.15	1,291,810,704.50	1,745,912,460.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(167,719,228.31)	(167,719,228.31)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	399,748,482.67	54,353,273.15	1,124,091,476.19	1,578,193,232.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	468,960,128.00	571,658,076.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	934,000.00	982,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	934,000.00	982,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	934,000.00	982,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	934,000.00	982,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,026,128.00	570,675,276.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,512,228.00	47,874,476.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,941,339.00	26,995,706.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,570,889.00	20,878,770.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,513,900.00	522,800,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,513,900.00	522,800,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	447,733,628.00	471,585,876.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,733,628.00	471,585,876.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,940,043.05	431,799,604.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,010,477.04	212,763,128.44
210101	Үндсэн цалин	150,153,952.39	158,438,294.29
210102	Нэмэгдэл	43,197,424.65	51,065,834.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,871,000.00	3,259,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,788,100.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,109,197.30	27,689,257.51
210201	Тэтгэврийн даатгал	18,127,013.16	19,360,047.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,118,854.15	2,150,294.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,611,070.34	1,715,867.22
210204	Ажилгүйдлийн даатгал	399,506.88	405,785.22
210205	Эрүүл мэндийн даатгал	3,852,752.77	4,057,262.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,499,667.71	61,545,422.61
210301	Гэрэл, цахилгаан	5,715,536.71	5,467,422.61
210302	Түлш, халаалт	59,784,131.00	54,978,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,223,056.00	21,884,518.00
210401	Бичиг хэрэг	2,827,600.00	2,111,250.00
210402	Тээвэр, шатахуун	14,583,312.00	15,377,194.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,244,744.00	2,128,624.00
210404	Ном, хэвлэл	18,500.00	6,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,548,900.00	2,260,950.00
2105	Нормативт зардал	738,400.00	296,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	738,400.00	296,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,558,600.00	5,881,550.00
210602	Тавилга	-	217,900.00
210604	Урсгал засвар	7,558,600.00	5,663,650.00
2107	Томилолт, зочны зардал	6,071,500.00	5,282,000.00

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	6,071,500.00	5,282,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,918,683.00	25,467,566.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,012,976.00	19,964,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,840.00	502,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	281,100.00	205,666.65
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	31,767.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,810,462.00	70,989,961.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,844,762.00	70,669,961.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	965,700.00	320,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,793,584.95	39,786,271.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,220,000.00	6,430,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,220,000.00	6,430,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,573,584.95	33,356,271.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,573,584.95	33,356,271.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,226,500.00	100,072,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,226,500.00	100,072,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,226,500.00	100,072,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,226,500.00	100,072,200.00
223001	Бусад хөрөнгө	21,226,500.00	100,072,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,226,500.00)	(100,072,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	523,700,800.00	490,501,872.21	33,198,927.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,700,800.00	420,856,372.21	32,844,427.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,220,800.00	419,376,372.21	32,844,427.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,874,400.00	212,763,128.44	15,111,271.56
210101	Үндсэн цалин	172,931,200.00	158,438,294.29	14,492,905.71
210102	Нэмэгдэл	51,007,200.00	51,065,834.15	(58,634.15)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,936,000.00	3,259,000.00	677,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,850,800.00	27,689,257.51	3,161,542.49
210201	Тэтгэврийн даатгал	21,709,800.00	19,360,047.77	2,349,752.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,285,300.00	2,150,294.40	135,005.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,828,200.00	1,715,867.22	112,332.78
210204	Ажилгүйдлийн даатгал	457,000.00	405,785.22	51,214.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,570,500.00	4,057,262.90	513,237.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,763,200.00	61,398,786.61	1,364,413.39
210301	Гэрэл, цахилгаан	6,663,700.00	5,320,786.61	1,342,913.39
210302	Түлш, халаалт	54,978,100.00	54,978,000.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,121,400.00	1,100,000.00	21,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,103,100.00	18,406,018.00	1,697,082.00
210401	Бичиг хэрэг	2,528,000.00	2,111,250.00	416,750.00
210402	Тээвэр, шатахуун	13,760,900.00	13,758,694.00	2,206.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,944,000.00	2,068,624.00	875,376.00
210404	Ном, хэвлэл	271,000.00	6,500.00	264,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	599,200.00	460,950.00	138,250.00
2105	Нормативт зардал	590,000.00	296,200.00	293,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	590,000.00	296,200.00	293,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,877,500.00	9,441,350.00	1,436,150.00
210602	Тавилга	4,000,000.00	3,777,700.00	222,300.00
210604	Урсгал засвар	6,877,500.00	5,663,650.00	1,213,850.00
2107	Томилолт, зочны зардал	4,500,000.00	4,499,000.00	1,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,499,000.00	1,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,855,300.00	23,383,116.65	3,472,183.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,980,000.00	17,880,000.00	3,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	503,500.00	502,450.00	1,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	205,666.65	46,333.35

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	55,000.00	31,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	4,200,000.00	-
210807	Газрын төлбөр	293,800.00	-	293,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,806,500.00	61,499,515.00	6,306,985.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,000,000.00	61,179,515.00	5,820,485.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	806,500.00	320,000.00	486,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,480,000.00	1,480,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,480,000.00	1,480,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,480,000.00	1,480,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,000,000.00	69,645,500.00	354,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,000,000.00	69,645,500.00	354,500.00
223001	Бусад хөрөнгө	70,000,000.00	69,645,500.00	354,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	523,700,800.00	490,501,872.21	33,198,927.79
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	522,800,800.00	489,519,072.21	33,281,727.79
132001	Орон нутгийн төсвөөс	522,800,800.00	489,519,072.21	33,281,727.79
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	900,000.00	982,800.00	-82800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	900,000.00	982,800.00	-82800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	17.00	
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	4.00	
620003	Үйлчлэх ажилтан	5.00	4.00	
620004	Гэрээт ажилтан	3.00	2.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,799,932.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,133,032.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,183,032.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,636.00
210301	Гэрэл, цахилгаан	146,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,478,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,618,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	783,000.00
210702	Дотоод албан томилолт	783,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,084,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,084,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,690,446.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,690,446.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,950,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,950,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,950,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,666,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,666,900.00
223001	Бусад хөрөнгө	25,666,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,799,932.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,799,932.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,995,706.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,804,226.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах,...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 623.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,578.1 сая төгрөг болж, өмнөх оноос 167.7 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	5.4	5.4	-
Урьдчилгаа	8.8	17.0	8.2
Бараа материал	74.4	56.7	(17.7)
Үндсэн хөрөнгө	1,657.2	1,499.0	(158.2)
Нийт хөрөнгө	1,745.8	1,578.1	(167.7)
Өр төлбөр			-
Засгийн газрын оруулсан капитал	399.7	399.7	-
Хуримтлагдсан үр дүн	1,291.8	1,124.1	(167.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54.3	54.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,745.8	1,578.1	(167.7)

Урьдчилгаа дансны үлдэгдэл 17.0 сая төгрөг болж, 8.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд тавилга эд хогшил, дүрэмт хувцас худалдан авахаар урьдчилж гарсан зардалтай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56.7 сая төгрөг болж 17.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,499.0 сая төгрөг болж 158.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 266.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 8.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, 86.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 68.1 сая төгрөгийг үнэ төлбөргүй орлого авсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,124.1 сая болж 167.7 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 22.2 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 99.3 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9.0 сая төгрөгөөр, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 89.2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 10.4 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний бусад зардал 24.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 6.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 3.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 533.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9.5 сая төгрөгөөр бууруулж 523.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 523.7 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 522.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 522.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая, нийт 523.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 490.5 сая төгрөгийг зарцуулж 33.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.8 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн

захирагчид хуваарилсан хөрөнгө 27.0 сая төгрөг, нийт 48.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт мэдээлбэл зохих 913.9 сая төгрөгийн 67 мэдээллээс 661.2 сая төгрөгийн 53 мэдээллийг мэдээлж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 114.7 сая төгрөгийн 6, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 23.4 сая төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, зарлагын 114.7 сая төгрөгийн 6 гүйлгээ, нийт 252.7 сая төгрөгийн 14 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнөөс 1 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар малын дансны тайлан тооцоог тулган шалгах аар шийдвэрлэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 252.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 252.7 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Тайлант онд нийт мэдээлбэл зохих 913.9 сая төгрөгийн 67 мэдээллээс 661.2 сая төгрөгийн 53 мэдээллийг мэдээлж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 114.7 сая төгрөгийн 6, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 23.4 сая төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, зарлагын 114.7 сая төгрөгийн 6 гүйлгээ, нийт 252.7 сая төгрөгийн 14 мэдээллийг мэдээлээгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газар	0	0								
Дүн		0	0								
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газар	1	252.7					1	252.7		
Дүн											
Нийт дүн		1	252.7					1	252.7		

6. Аудитын тайлангийн хавсралт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 85/АДЗ70/447
ХЭА-2022/111/1А-СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн дансанд Онон голын гүүрний хураамжийн орлого 5,151.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.9 дэх "Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.9.3 "хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого" заалтад нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын төсвийн орлогод төвлөрүүлэх орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлдэг зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дадал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Гэрэлмаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА